

ТӨВ ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВҮҮДИЙН ХҮЛЭЭГДЛИЙН МЭДЭЭНИЙ НЭГТГЭЛ

/2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар/

1. УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛЭГ

Тус эмнэлгээс ирүүлсэн мэдээллээс харахад нийт 19 үйлчлүүлэгч мэргэжлийн эмчид үзүүлэхээр 3-с дээш хоног хүлээж байна. Хүснэгт 1.

Хүснэгт 1. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн амбулаторийн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1.	Бөөр судлал	-	-	6	6
2.	Мэдрэл судлал	-	3	-	3
3.	Хоол боловсруулах эрхтэн судлал	3	-	-	3
4.	Нүд судлал	-	-	2	2
5.	Булчирхай судлал	-	-	2	2
6.	Зүрх судас	1	-	-	1
7.	Чих хамар хоолой судлал	-	1	-	1
8.	Хэрх үе судлал			1	1
	Нийт	4	4	11	19

2025 оны 2 сард тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ маш их хүлээгдэлтэй байна. Эмнэлгийн хэмжээнд нийт 2430 үйлчлүүлэгч 3-с дээш хоногийн орны хүлээгдэлтэй байна. Нүд, Чих, хамар, хоолой, Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлэхээр хамгийн их иргэн хүлээж байна. Нүдний тасагт хэвтэн эмчлүүлэхээр 1168 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь нийт хүлээгдлийн тал хувийг эзэлж байна. Мөн хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн 72.3% нь 1 сараас дээш хугацаагаар ор хүлээж байна.Хүснэгт 2.

Хүснэгт 2. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1.	Нүд судлал	85	85	158	840	1168
2.	Чих, хамар, хоолой судлал		10	30	862	902
3.	Бүдүүн шулуун гэдэсний мэс засал	18	20	83	-	121
4.	Урологи	27	22	16	29	94
5.	Мэс засал судлал	28	15	20	25	88
6.	Хоол боловсруулах эрхтэн судлал	10	9	7	2	28
7.	Цусны эмгэг судлал	10	5	1	1	17

8.	Уушги судлал		4	1		5
9.	Мэдрэл судлал	2	2			4
10.	Дотоод шүүрэл	2				2
11.	Бөөр судлал		1			1
	Нийт	182	173	316	1759	2430

Оношилгооны чиглэлээр КТГ шинжилгээ хийлгэхээр нийт 90 хүн 7-14 хоног, ходоодны дуран хийлгэхээр 50 хүн 3-14 хоногийн хүлээгдэлтэй байна. Хүснэгт 3.

Хүснэгт 3. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн оношилгооны хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа					Бүгд
		Өдөртөө	1-3 хоног	3-6 хоног	7-14 хоног	15 ба түүнээс дээш	
1	MRI				10		10
2	Ходоодны дуран		10	20	30		60
3	КТГ		72	36	90		198
	Нийт	-	82	56	130	-	268

2. УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ

Тус эмнэлэгт 166 иргэн амбулаторийн 10 чиглэлийн кабинетийн эмчид үзүүлэхээр 3-с дээш хоног хүлээж байна. Хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж, үйлчилгээнд Хоол боловсруулах эрхтэн судлалын эмчийн үзлэг орж байна. Хүснэгт 4.

Хүснэгт 4. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Өдөртөө	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
			3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	51	9	2	39	101
2	Зүрх судас	73	18		1	92
3	Мэс засал судлал	45	13	2	4	64
4	Бөөр судлал	24	5	1	10	40
5	Эмэгтэйчүүд судлал	18	4		10	32
6	Нүд судлал	13	11	6	2	32
7	Урологи	30				30
8	Уушги судлал	13	11			24
9	Мэдрэл судлал	13	1		9	23
10	Чих хамар хоолой судлал	7	1		7	15
	Нийт	287	73	11	82	453

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 83 иргэн 3-с дээш хоног хүлээж байна. Рентген оношилгоо хийлгэхээр 30, хэвлийн эход харуулахаар 43, зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 6 иргэн тус бүр 3-аас дээш хоног хүлээж байна. Хүснэгт 5.

Хүснэгт 5. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн оношилгооны хүлээгдэл

№	Оношилгоо	Хүлээгдлийн хугацаа				Нийт
		Өдөртөө	3-6 хоног	7-14 хоног	15-с дээш хоног	
1	Рентген зураг	65	15	2	13	95
2	Хэвлийн эхо	43	13	8	22	86
3	Зүрхний цахилгаан бичлэг	55	6			61
4	MRI/CT	11	3		1	15
5	Холтер	2				2
6	Тархины цахилгаан бичлэг	1				1
	Бүгд	177	37	10	36	260

Тус эмнэлэгт лабораторийн тусламж, үйлчилгээ авахаар хүлээж буй иргэдийн 0.09% нь 3-6 хоног хүлээж байгаа ба шинжилгээний хүлээгдэл харьцангуй бага байна. Хүснэгт 6.

Хүснэгт 6. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Шинжилгээний нэр	Хүлээгдлийн хугацаа				Нийт
		Өдөртөө	3-6 хоног	7-14 хоног	15-с дээш хоног	
1	Серологи шинжилгээ	58	6			64
2	Цитологи	83	5			88
3	Шээсний шинжилгээ	84	6			90
4	Иммунологи	188	21			209
5	Цусны шинжилгээ	208	3			211
6	Биохимийн шинжилгээ	1787	112	1		1900
	НИЙТ	2408	153	1		2562

Тус эмнэлгийн орны хүлээгдэл 494 үйлчлүүлэгч 3-с дээш хоног ор хүлээж байна. Чих, хамар, хоолойн тасагт 225, Хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт 129, Мэс заслын тасагт 53 хүн хэвтэн эмчлүүлэхээр тус тус ор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна. Хүснэгт 7.

Хүснэгт 7. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа				Бүгд
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	1 сараас дээш	
1	Чих, хамар, хоолой судлал	52	65	71	37	225
2	Хоол боловсруулах эрхтэн судлал	22	15	25	67	129
3	Мэс засал судлал	34	17	2		53
4	Эмэгтэйчүүд судлал	6	12	25		43
5	Урологи	11	14	13		38
6	Мэдрэл судлал	6				6
	Нийт	131	123	136	104	494

3. УЛСЫН УЛСЫН ГУРАВДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГ

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл их, 814 иргэн 17 чиглэлийн нарийн мэргэжлийн эмчид үзүүлэхээр 3-с дээш хоног хүлээж байна. Мэдрэлийн эмчид үзүүлэхээр 125, Зүрхний эмгэг судлалын эмчид үзүүлэхээр 113, Зүрхний мэс засал судлалд үзүүлэхээр 59 үйлчлүүлэгч 3 ба түүнээс дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй үзлэгт хамаарч байна. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 32.4% (264) нь 7 ба түүнээс дээш хоног хүлээж байна. Хүснэгт 8.

Хүснэгт 8. Улсын гуравдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			Нийт
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1.	Мэдрэл судлал	59	10	56	125
2.	Зүрхний эмгэг судлал	53	15	45	113
3.	Зүрхний мэс засал судлал	31	3	25	59
4.	Мэдрэлийн мэс засал	31	5	20	56
5.	Мэс засал судлал	36	6	12	54
6.	Хоол боловсруулах эрхтэн судлал	31	2	15	48
7.	Чих хамар хоолой судлал	28	2	16	46
8.	Нүд судлал	27	2	10	39
9.	Урологи	27	3	8	38
10.	Зүрх /хэм алдагдал/	21	2	15	38
11.	Сонсгол	20	6	10	36
12.	Бөөр судлал	17	10	8	35
13.	Үе судлал /Ревматологи/	24	2	7	33
14.	Уламжлалт	20	4	5	29

15.	Уушиг судлал	21	2	6	29
16.	Сэргээн засах	20	2	6	28
17.	Булчирхай судлал	6	2		8
	Нийт	472	78	264	814

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 294 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байна. Зүрхний цахилгаан бичлэг хийлгэхээр 100 үйлчлүүлэгч, хэвлийн эхо-д харуулахаар 57 үйлчлүүлэгч хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй оношилгоонд тус тус хамаарч байна. Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчдийн дийлэнх буюу 91.4% (269) нь 3-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Хүснэгт 9.

Хүснэгт 9. Улсын гуравдугаар төв эмнэлгийн оношилгооны хүлээгдэл

№	Оношилгоо	Хүлээгдлийн хугацаа			Нийт
		3-6 хоног	7-14 хоног	15-с дээш хоног	
1.	Зүрхний цахилгаан бичлэг	100			100
2.	Хэвлийн эхо	57			57
3.	Зүрхний эхо	30	2	2	34
4.	Тархины цахилгаан бичлэг	20	5	5	30
5.	Холтер	23	2	5	30
6.	Рентген зураг	27	3		30
7.	Доплер	11	1		12
8.	Дуран	1			1
	Бүгд	269	13	12	294

Харин тус эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээ авахаар 675 үйлчлүүлэгч хүлээж байгаа ба 26.2% (177) нь 3-аас дээш хоногийн хүлээгдэлтэй байна. Цусны шинжилгээ хийлгэхээр 40, биохимийн шинжилгээ хийлгэхээр 40, шээсний шинжилгээ хийлгэхээр 40 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй шинжилгээнд хамаарч байна. Хүснэгт 10.

Хүснэгт 10. Улсын гуравдугаар төв эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Шинжилгээний нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		Өдөртөө	3-6 хоног	7-14 хоног	
1.	Цусны шинжилгээ	160	40		200
2.	Биохимийн шинжилгээ	140	40		180
3.	Шээсний шинжилгээ	80	40		120
4.	Коагулограмм	45	16		61
5.	Иммунологи	34	15		49
6.	Бактерлогийн шинжилгээ	23	10		33
7.	Серологи	16	16		32
	Нийт	498	177		675

Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ хүлээгдэл ихтэй байгаа ба нийт 221 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байна. Мэдрэлийн мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 70, Нүдний тасагт хэвтэн эмчлүүлэхээр 42 үйлчлүүлэгч 3-с дээш хоногоор ор хүлээж байгаа нь хамгийн их орны хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна. Хүснэгт 11.

Хүснэгт 11. Улсын гуравдугаар төв эмнэлгийн орны хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хэвтүүлэн эмчлэх ор хүлээж байгаа хоногийн тоо	Ор хүлээж буй үйлчлүүлэгчийн тоо
1	Мэдрэлийн мэс заслын тасаг	3-6 хоног	20
		7-14хоног	20
		15-30 хоног	15
		1 сараас дээш	15
		Нийт	70
3	Мэдрэлийн тасаг	3-6 хоног	11
		7-14хоног	3
		Нийт	14
5	Нүдний тасаг	3-6 хоног	12
		7-14хоног	9
		15-30 хоног	10
		1 сараас дээш	11
		Нийт	42
5	Бөөр судлал	3-6 хоног	16
		7-14хоног	2
		15-30 хоног	4
		1 сараас дээш	
		Нийт	22
7	Уламжлалт эмчилгээ судлал	3-6 хоног	4
		7-14хоног	
		Нийт	4
9	Зүрхний мэс засал /судасны мэс засал /	3-6 хоног	6
		7-14хоног	4
		15-30 хоног	1
		Нийт	11
10	Зүрх судас судлал	3-6 хоног	9
		7-14хоног	9
		15-30 хоног	
		1 сараас дээш	
		Нийт	18
11	Мэс засал судлал	3-6 хоног	4
		7-14хоног	10
		15-30 хоног	10
		Нийт	24
12	Уушги судлал	3-6 хоног	6
		7-14хоног	1
		Нийт	7
13	Хоол боловсруулах эрхтэн судлал	3-6 хоног	6
		7-14хоног	2

		15-30 хоног	1
		Нийт	9
	Бүгд	3-6 хоног	94
		7-14хоног	60
		15-30 хоног	41
		1 сараас дээш	26
		Нийт	221

4. ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар нийт 720 үйлчлүүлэгч 3-аас дээш хоног хүлээж байна. Хүүхдийн мэс заслын эмчид үзүүлэхээр 102, насанд хүрэгсдийн мэс заслын эмчид үзүүлэхээр 99, гар сарвууны мэс заслын эмчид үзүүлэхээр 99 үйлчлүүлэгч тус тус хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна. Хүснэгт 12.

Хүснэгт 12. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо			Нийт
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1.	Хүүхдийн мэс засал	57	21	24	102
2.	Насанд хүрэгсдийн мэс засал	66	17	16	99
3.	Гар сарвууны бичил мэс засал	70	23	6	99
4.	Амбулаторийн эмчийн үзлэг	45	51		96
5.	Нөхөн сэргээх мэс засал	48	2	1	51
6.	Ясны эмгэгийн мэс засал	38	7	2	47
7.	Толгойн мэс засал	38	3	5	46
8.	Зүрх судасны эмчийн үзлэг	38	1		39
9.	Түлэнхий, нөхөн сэргээх мэс засал	35	1	1	37
10.	Хавсарсан гэмтлийн мэс засал	30	1	1	32
11.	Спортын гэмтлийн мэс засал	8		21	29
12.	Чих хамар хоолойн мэс засал	16	1	1	18
13.	Нурууны мэс засал	8	1	32	11
14.	Нүүр амны мэс засал	8			8
15.	Нүдний мэс засал	3			3
16.	Сэргээн засах эмчилгээ	3			3
	Нийт	511	129	110	720

ГССҮТ-д MRI оношилгоонд хамрагдахаар 100 үйлчлүүлэгч 3-6 хоног хүлээж байна. КТГ, Рентген, Хэвлийн эхо-д харуулахаар 45 үйлчлүүлэгч мөн адил 3-6 хоногийн хүлээгдэлтэй байна. Хүснэгт 13.

Хүснэгт 13. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн оношилгооны хүлээгдэл

№	Оношилгоо	Хүлээгдлийн хугацаа				Нийт
		Өдөртөө	3-6 хоног	7-14 хоног	15-с дээш хоног	
1.	Хэвлийн эхо	11	5			16
2.	Рентген зураг	12	15			27
3.	КТГ	20	25			45
4.	MRI	10	60	40		110
	Бүгд	53	105	40		198

Тус эмнэлгийн орны хүлээгдэл 25 үйлчлүүлэгч 3-с дээш хоног ор хүлээж байна. Гар сарвууны бичил мэс засал 4, Нөхөн сэргээх мэс засал, насанд хүрэгсдийн мэс заслын тасагт хэвтэн эмчлүүлэхээр 3 үйлчлүүлэгч тус бүр 3 хоног хүлээж байна. Хүснэгт 14.

Хүснэгт 14. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо			Нийт
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1.	Нүдний мэс засал	1			1
2.	Хүүхдийн мэс засал	1			1
3.	Толгойн мэс засал	1	1		2
4.	Сэргээн засах эмчилгээ	2			2
5.	Ясны эмгэгийн мэс засал	2	1		3
6.	Спортын гэмтлийн мэс засал	2	1		3
7.	Түлэнхий, нөхөн сэргээх мэс засал	3			3
8.	Насанд хүрэгсдийн мэс засал	2	1		3
9.	Нөхөн сэргээх мэс засал	2	1		3
10.	Гар сарвууны бичил мэс засал	2	2		4
	Нийт	18	7		25

5. ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Тус төв нь 2025 оны 1 сард хүлээгдэлгүй ажилласан байна.

6. Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Өргөө, Амгалан амаржих газрууд, Эх, хүүхэд, нярайн төв-2, Халдварт өвчин судлалын үндэсний төв, АӨСҮТ, ГССҮТ, СЭМҮТ, Хүүхдийн төв сувилал болон Нийслэлийн эрүүл мэндийн газар хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.